

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС УЛСЫН ХИЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО, ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬТАЙ ХОЛБОГДОХ НЬ MONGOLIAN NATIONAL GOVERNMENT'S POLICY ON BORDER AND LAW ENFORCEMENT ASSOCIATED WITH UNIVERSITIES



Ш.Арвай. ХСИС-ийн ШУТГ-ын Хил судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, цэргийн шинжлэх ухааны доктор, профессор, дэслэгч генерал

Arvai.Sh. Senior scientific researcher of Limnology Center, Department of Science and Technology, Emeritus of Science, Sc.D, Professor, Lieutenant general

Abstract: Mongolian national independence and powers to ensure the territorial integrity of the origin of legal and policy documents, such as the state border policy discontinuity to be successful, the state and the people trusted to train personnel officer khilchin people originated famous Central School 80 years of law enforcement history, role and development trend of the border guards said security verification link.

Монгол улсын хилийн цэрэг буюу хил хамгаалах байгууллага орчин үеийн шинж агуулгатайгаар үүсэж хөгжсний 80 жилийн ойг 2012 онд өргөн цар хүрээнд ард түмэн, анд нөхдийнхөө хамт тэмдэглэсэн билээ. Энэ үеэр “Улсын хил хамгаалалтын түүхэн сургаж 80 жил” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг ХХЕГ-аас Хууль Сахиулахын Их сургуулийн эрдэмтэн судлаачид, багш нартай хамтарч явуулав.

Өнгөрсөн зуу шахам жилийн хугацааны улсын хилийн баталгаажилт, хамгаалалтын бодлого үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, хил хамгаалах урлагийн хөгжилд оруулсан хувь нэмэр сургамжийг товойлгон гаргаснаар энэ эрдэм шинжилгээний хурал онцгой ач холбогдолтой болсон гэж олон нийтээс өндөр үнэлэлт авсан байна.

Эрдэм шинжилгээний хурал дээр Хил Хамгаалах Ерөнхий газрын дарга, цэргийн ухааны доктор, профессор, бригадын генерал Ш.Лхачинжав тавьсан илтгэлдээ “олсон амжилт, гавьяа бол манай үе үеийн ахмад хилчдээс залуу үеийн хилчиддээ их ойтой холбогдуулан өргөн барьж байгаа үнэтэй бэлэг” гэдгийг онцлоод “Орчин үед манай хилчдэд хил хамгаалах байгууллагын хувьд улсын хилийн баталгаажилт, хамгаалалтыг шийдвэрлэх амаргүй зорилт тулгарч байгааг бид мэдэрч байна. Энэ нь сансар, мэдээлэл даяаршлын эрин зууны онцлогт тохирсон, НҮБ-ын дүрэм, бусад олон улсын эрх

зүй, хүн төрөлхтний гурав дахь мянганы зорилт, Монгол Улсын бие даасан хөгжлийн эрх ашигт нийцүүлэн улсынхаа хилийн аюулгүй байдлыг хангах том зорилтоос урган гарч байна ” (1.17,18) гэж тэмдэглэжээ.

Энд дурдагдсан үнэлгээ, дэвшигдсэн зорилт нь Хууль Сахиулахын Их Сургууль, түүний тулгуур баганы нэг болох хил судлалын эрдэм шинжилгээний байгууллага, хилийн албаны сургуультай амин холбоотой гэдэгт эргэлзэх шалтгаан байхгүй. Яагаад гэвэл, Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангахад төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого зайлшгүй шаардагдахын зэрэгцээ тэрхүү стратегийн зорилтыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд төр, ард түмний итгэл даах хилчин офицер боловсон хүчнийг сургаж бэлтгэх төрийн бодлого хослон гарч иржээ.

Намын Төв Хороо, Ардын Сайд Нарын Зөвлөлийн 1933 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 8 дугаар тогтоолоор Дотоодын Хамгаалах Газарт дунд сургууль байгуулах эрх нээгджээ. 1933 оны 12 дугаар сарын 01-ны өдөр Дотоодыг Хамгаалах Газар (ДХГ)-ын дэргэд хязгаарын ба гүйцэтгэх ажилтны нэг жилийн курс нээгдэн улмаар 1934 оны 9 дүгээр сарын 19-ны өдөр ДХГ-ын даргын 687 тоот тушаалаар (2.7,8) сургууль албан ёсоор үйл ажиллагаагаа эхэлсэн боловч ДХГ-ын даргын 1934 оны 12 дугаар сарын 11-ны өдөр

гаргасан тушаалаар тус цэргийн дунд сургуулийг Төв сургууль хэмээн нэрлэх болсон нь ХСИС-ын үүсэл хөгжлийн эх үндэс болсон байна.

Хууль Сахиулахын Их сургууль үүсэл, хөгжлийнхээ 80 жилийн ойг 2014 онд тэмдэглэхээр олон төрөл, чиглэлийн өргөн арга хэмжээг авч байна. Өнгөрсөн 80 жилийн хугацаанд тус сургуулийн эгнээд хуулийн болон цэргийн дунд, дээд боловсролын төрөл мэргэжлийн олон мянган офицерууд бэлтгэгдэсний дотор хилийн албаны команд- штаб, улс төр, гүйцэтгэх албан, ар талын янз бүрийн мэргэжлийн олон зуун офицерууд бэлтгэгдэн гарч эх орон, ард түмэндээ үүрд үнэлэгдэн дурсагдах гавьяа байгуулсан юм.

Мөн хугацаанд хилийн ба дотоодын цэрэгт отрядын дарга, түүнээс дээших шатны албан тушаалын офицерууд мөн тодорхой үеүдэд цэргийн дунд, дээд боловсролтой офицеруудыг Зөвлөлт Холбоот улсын зэвсэгт хүчин, хилийн цэргийн дээд, дунд сургуулиудад бэлтгэж байсан боловч ихэвчлэн салаа, салбарын захирагч дарга нарыг бэлтгэх, давтан бэлтгэх, мэргэшүүлэх үүрэг хариуцлага төв сургуульд оногдсон байна. Бие бүрэлдэхүүний 80% нь хугацаат цэргийн алба хаагч эзэлж байсан тухайн үеийн отряд заставуудад улсын хил манах, хязгаар нутагт улс, нийгэм, ард иргэдийн эрх ашгийг өдөр шөнөгүй, тайван болон байлдааны цагт хамгаалах хамгийн хариуцлагатай хүнд албыг зохион байгуулж хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага төв сургуулийн үндсэн бүтээгдэхүүн болох офицеруудад оногдож байлаа.

Тэд захирагдсан хилчин дайчдыг эцэг эхийн ёсоор энэрэн хайрлаж, алба байлдааны хэрэгцээтэй бүхэнд сургаж, эх оронч нугаршгүй хатан зориг, хүмүүжил, ёс суртахууны чанар шингээж, зэвсэг байлдааны техникийг мастерын ёсоор эзэмшүүлж, шаардагдах бүхнээр тасралтгүй хангаж, хил манах, хамгаалах ур ухаан суулгаж тавигдсан зорилт, өгөгдсөн үүргийг нэр төртэй хэрэгжүүлэх бүх талын нөхцлийг чадварлаг бүрдүүлэхэд онцгой анхаарч байжээ. Энэ нь манай мянга, мянган хилчид эх орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлыг улсын хил, хязгаарт бүрэн дүүрэн хангах таатай нөхцлийг бүрдүүлэхэд шийдвэрлэх нөлөөтэй чухал хүчин зүйлүүдийн нэг нь болж байсныг харуулдаг.

Манай сургуулийн анхны төгсөгчдийн нэг эх оронч хурандаа Борын Цэвэгжав, М.Цэдэндамба мөн, Дүнгэрийн Лувсандаш зэрэг олон арван офицеруудын удирдсан анги салбарууд Монгол улсын зүүн ба өмнөд чиглэлийн хоёр мянга хоёр зуун км урт хэсэгт гадаадын түрэмгийлэл, халдлага, өдөөн хатгалга, хорлон сүйтгэгчдийн эсрэг эрэлхгээр зогсож чадварлагаар манаж хамгаалав. Ялангуяа Буйр нуур, Халхын голын дорнод хэсэгт XVIII, XIX зуун үед тогтоогдсон хилийг Японы цэргийн түрэмгийлэгчид санаатайгаар өөрчлөн улсын хил Буйр нуурын наагуур, Халх голоор байсан мэт домог зохион дэгдээсэн Халхын голын дайнд Зөвлөлт

Монголын цэрэг ялалт байгуулан, Японы цөмөрсөн цэргийн хүчийг бут цохин, үлдсэн хэсгийг хөөн гарган улсын хилийг уламжлалт урьдын хэмжээнд сэргээн тогтооход хилийн анги салбарууд, хилчид оролцож гавьяа байгуулав.

Монгол улсын баруун, баруун өмнөд хязгаарт 1934-1948 оны хооронд гадаадын өдөөсөн удаа дараагийн зэвсэгт халдлага өнгөлзөлгөөс эх орноо хамгаалаж хил хязгаарын аюулгүй байдлыг хангах үйлсэд Монгол улсын баатар С.Лхагвадорж, эх оронч Г.Хаянхярваа зэрэг тус сургуулийн олон арван офицерууд анги салбараа чадамгай удирдан оногдсон үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн байна.

Дэлхийн II дайны төгсгөлийн ажиллагааг зүүн, зүүн өмнөд Ази, Номхон далайн сав газарт амжилттай дуусгавар болгон, олон улсын хэмжээнд энх тайван найрамдлыг бэхжүүлэх их үйл хэрэгт тухайн чиглэлийн хилийн найман отряд оролцоход манай сургуулийг төгсгөсөн алдарт хилчин, отрядын дарга Ш.Зонров зэрэг олон офицеруудын удирдсан бүлгүүд байлдааны үүргээ амжилттай гүйцэтгэсэн түүх бий.

Манай сургуулийн штабын дарга асан, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Гавьяат хуульч Б.Цэдэн-Иш, хурандаа Э.Халтар, тус сургуулийн төгсөгч хурандаа Ч.Дамбийням, Б.Ёндон, Ш.Бөнжин зэрэг олон офицерууд Монгол улсын 8252,6 км урт хилийг тогтоон тэмдэглэхэд бүтээлчээр оролцож төрөөс улсын хилийн баталгаажилтын талаар баримтлах бодлого амжилттай хэрэгжихэд үүрд дурсагдах жинтэй хувь нэмэр оруулав.

Тус сургууль олон төрөл мэргэжлийн өндөр боловсролтой, чадвартай боловсон хүчнийг бэлтгэж төр засгаас дэвшүүлсэн зорилтууд, ард түмний өндөр итгэл найдварыг нэр төртэй хэрэгжүүлж гавьяа байгуулсныг тэмдэглэж 1984 онд Байлдааны гавьяаны одонгоор шагнагджээ.

Манай алдарт сургуулийг хөл дээр нь босгож үүсэж хөгжүүлэхэд Э.Галсан, Б.Арвинийсүрэн, Ж.Лувсан, Д.Ядамжав, Д.Дашдаваа, Д.Буяндэлгэр, Э.Халтар, Ш.Зонров, Т.Нанзад, Ж.Рэнчин, Л.Намсрай, Я.Рагчаа, Г.Бямбасүрэн, Р.Гүнсэн, Т.Лхагвасүрэн, Ч.Жазаг, Ц.Энхжаргал, М.Лхагвасүрэн, Я.Пүрэвдорж, П.Даш, А.Муратхан, Н.Наранжамц, Д.Дашдаваа, Ц.Ганболд зэрэг шилдэг дарга захирагчид өөр өөрийн өвөрмөц онцлогтой тодорхой хувь нэмэр оруулж амжилт гаргасан байна. Мөн 1998-2011 оны хооронд Хилийн цэргийн дээд сургууль, Цагдаагийн академи тус тусдаа оршин байх тодорхой хугацаанд ч манай сургуулиудын хамтын ажиллагаа цалгардаж байгаагүйг тэмдэглүүштэй. Төрөөс боловсрол, шинжлэх ухааны талаар баримтлах бодлогын хүрээнд 2011 онд Монгол Улсын Засгийн газрын 299 дүгээр тогтоол гарч Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийг нэгтгэн Дотоод хэргийн их сургууль болгон, тус сургуулийн захирлаар томилогдсон доктор, профессор, цагдаагийн

хурандаа Б.Болдбаатар томоохон зорилтуудыг дэвшүүлэн ажиллав.

2012 онд Монгол Улсын Засгийн газрын 87 дугаар тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийг Хууль сахиулахын их сургууль болгон тодотгож тус сургуулийн захирлаар өндөр боловсрол, арвин туршлагатай шилдэг хуульчдын нэг болох профессор, цагдаагийн хурандаа Р.Чингис томилогдон, түүний тодорхойлсноор манай сургууль “Хууль сахиулах болон үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын захиалгаар бэлтгэж байгаа мэргэжилтний сургалт, эрдэм шинжилгээний ажлын арга, арга зүй, технологид хууль зүйн салбарын шинэчлэлтэй уялдуулан өөрчлөлтийг үе шаттай” амжилттай хэрэгжүүлэн ойгоо угтаж байна.

Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг улсын хил, хязгаарт хангахад эдүгээч манай сургуулийн эрдэмтэн, профессорууд, багш нар тус сургуулийг төгссөн ахлагч, офицерууд эх орон, ард түмнийхээ өмнө хүлэсэн үүргийг нэр төртэй гүйцэтгэж байгаа төдийгүй зарим нь НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд амжилттай оролцож байна.

Монгол улсын хил хамгаалах бодлого үйл ажиллагаанд амжилтаас гадна гаргаж байсан алдаа бий. 1950-аад оны эхээр “10570 хүний бие бүрэлдэхүүн бүхий хилийн цэргийн байгууллагыг бүхлээр нь татан буулгаж 213 хилчинг үлдээж” (1.18) цэргээр хил хамгаалах ажиллагааг зогсоон зөвхөн 12 пункт, гүйцэтгэх албаны үндсэн хүчээр хилийн асуудлыг шийдэх бололцоотой гэж төр засаг үзсэн байна. Улсын хил тогтоогдоогүй байсан тухайн үед энэ алдаанаас болж улсынхаа хязгаар нутгаас чимх чимхээр алдахад хүрсэн аюултай тулгарчээ.

Үүний үндсэн шалтгаан нь тухайн үед Үндэсний аюулгүй байдлын бодлого, тэр дотроос улсын хил судлалын шинжлэх ухаан үгүйлэгдэж судалгаа, шинжилгээ хийдэг эрдэмтэн, судлаачид дутагдсанаас бодит байдлыг объектив мэдлэгийн түвшинд судлан шинжилж, үр дүнг төр засагт танилцуулж, бүтээлч шийдвэр гаргуулах нөхцөл бололцоо хомс байсантай холбон үзэж болохуйц дүр зураг гарч ирдэг.

XXI зуунд энэ алдааг давталгүй шинэ зуунд шилжин орлоо. Энэ нь Монгол улсын төрөөс улсын хил хязгаарын талаар баримтлах бодлогын бүтээлч чанарын илрэл яах аргагүй мөн. Монгол улсын одоогийн мөрдөгдөж байгаа 1992 оны Үндсэн хуулийг батлан гаргахад манай сургуулийн захирал асан, хошууч генерал Я.Пүрэвдорж, хурандаа М.Лхагвасүрэн зэрэг хилчид биечлэн оролцов. Улсын Их Хурлын гишүүнээр хилчин эрдэмтэн, хошууч генерал Д.Базарсад, бригадын генерал Х.Жекей нар сонгогдон идэвхитэй ажиллав. Монгол улсын төр засаг, манай яам, ялангуяа Хил хамгаалах ерөнхий газар төр засгийн шийдвэрүүдийн төсөл боловсруулах, бэлтгэх, батлан гаргах үеүдэд хил хамгаалах байгууллагын эрдэмтэн судлаачдыг өргөн оролцуулж ашиглав. Тулгуур баримт бичгүүдийг

боловсруулахад миний судалгааны ажлын үр дүн, дүгнэлт саналыг боломжийн хэмжээнд авч байсанд баярладаг. Энэ их үйлсэд хил хамгаалах байгууллага болон тус сургуулийн эрдэмтэн П.Сүндэв, П.Даш, Н.Наранжамц, А.Муратхан, Э.Ганбаатар, Г.Эрдэнэбат (эдүгээгийн Улсын ерөнхий прокурорын орлогч), Ц.Ганболд судлаач Ч.Дашдэлэг, Д.Баатар, М.Ганболд зэрэг олон офицерууд үнэтэй хувь нэмэр оруулсан юм.

Монгол Улсын Хилийн тухай хууль 1993 онд батлагдан гарав. Төрөөс хилийн талаар баримтлах бодлого 2002 онд Монгол улсын Их Хурлын 20 дугаар тогтоолоор батлагджээ. Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар хил хамгаалалтын дүрэм I, II мөн улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам батлагдан хэрэгжиж байна. Улсын хилийн асуудлыг энхийн аргаар шийдвэрлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр ОХУ, БНХАУ, мөн дэлхий хамтын нийгэмлэгийн холбогдох улсуудтай гэрээ хэлэлцээрүүд байгууллагдав. Энэ мэтээр Төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдсон эрх зүй, хэм хэмжээний баримт бичгүүд гарч шийдвэрлэгдсэнээр улсын хил, хязгаарт үндэсний аюулгүй байдал хангагдахад тулгамдаж байгаа олон асуудлыг шийдвэрлэх таатай нөхцөл бүрдэж шаардлагатай арга хэмжээнүүдийг үе шаттайгаар тодорхой хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд Хууль сахиулах их сургууль ач холбогдолтой шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна. Манай олон төрлийн сургуулиуд нэгдэн нэгэн их сургууль болж хөгжиж байгаа нь тохиолдлын бус, зүй тогтлын шинжтэй бодит үзэгдэл мөн. Хүний нөөц буюу боловсон хүчнийг бэлтгэхэд зөвхөн сургалтын байр суурьнаас ихэвчлэн ханддаг байсан өрөөсгөл ёс журмыг халж, харин шинжлэх ухаан сургалт технологийг тэргүүлэх төвшинд тавьсан шинэ тогтолцоонд шилжсэн нь онцгой ач холбогдолтой, нэгэн хэлбэрийн дэвшил юм.

Өөрөөр хэлбэл, сургалт, эрдэм шинжилгээний тогтолцооноос эрдэм шинжилгээ сургалтын цоо шинэ тогтолцоонд шилжин орлоо. Манай их сургуулийн удирдлага санаачлан ХХЕГ-тай хамтран 2012 онд “Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа” сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Монгол улсын хэмжээнд анх удаа амжилттай зохион байгуулж явуулав. Энэ эрдэм шинжилгээний хурал нь эрдэм шинжилгээг тэргүүлэх зэрэгт дэвшүүлсэн тогтолцоонд салхи оруулсан анхны дорвитой арга хэмжээ байв.

Манай сургуулийн захирал профессор, цагдаагийн хурандаа Р.Чингис “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага” сэдвээр 2013 онд зохиогдсон олон улсын эрдэм шинжилгээний хурлыг нээж хэлэхдээ “Тус сургууль 2012 онд үндэстэн дамнасан зохион байгуулалттай

гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал", "хилийн аюулгүй байдал, хамтын ажиллагаа" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хоёр хурал амжилттай зохион байгуулж, зөвлөмж гарган, УИХ, Засгийн газар болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн нь бодит ажлын эхлэл болж зохих үр дүнгээ өгч эхэлснийг онцлон тэмдэглэсэн юм.

Улсын хилийн асуудал Монголд төдийгүй олон улсын эрх ашигтай холбогддог. 1966 онд батласан иргэний улс төрийн эрхийн тухай олон улсын пакт гэдэг баримт бичигт: "Бүх ард түмэн өөрөө засан тогтнох эрхтэй. Энэхүү эрхийнхээ дагуу тэд улс төрийн статусаа чөлөөтэй тогтоож, эдийн засаг, нийгэм соёлоо чөлөөтэй хөгжүүлнэ" гэдгийг заагаад "Бүх ард түмэн харилцан ашигтай байх зарчим дээр тулгуурласан олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаагаар болон олон улсын эрх зүйгээр хүлээсэн аливаа үүргээ хохироохгүйгээр байгалийн баялаг, нөөцөө өөрийн зорилгод чөлөөтэй захиран зарцуулна. Аль ч ард түмнийг ямарч тохиолдолд оршин тогтнох хэрэглүүрээс нь хагацааж үл болно" гэж тэмдэглэсэн байдаг.

"Монгол улсын хил халдашгүй дархан байна" гэдгийг Үндсэн хуулиар тунхагласан.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд "Улсын хилийг зөрчих, өөрчлөх нь" үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл гэдгийг тэмдэглэсэн. Эдгээр шаардлагууд улсын хил хязгаарт эерэгээр хангагдах бүх талын нөхцөл бүрдүүлэх нь хойшлуулашгүй томоохон зорилт болж байгаа юм. Монгол улс, БНХАУ-ын хооронд 1962 онд хилийн гэрээ байгуулж хилээ тогтоогоод 52 жил, ОХУ-тай 1976 онд хилийн баталгаажилтыг хамтран шийдвэрлээд 38 жил өнгөрч байна. Энэ нь харьцангуй бага хугацаа бөгөөд улсын хилийг инженер, техникийн хувьд төхөөрөмжлөх, хязгаар нутагт дэд бүтцийг хөгжүүлэхэд цаг хугацаа, хүч хэрэгслийн боломжийн хувьд хомс байгаа нь хэнд ч ойлгомжтой.

Улсын хилийг хууль бусаар нэвтрэх нь нэгэн зэрэг хоёр улсын хил зөрчиж байгаа ноцтой гэмт хэрэг болдог. Түүний уршиг нь их. Энэ хэрэг харьцангуй буурч байгаа ч гэсэн таслан зогсоогдох нөхцөл энэ хэр бүрдэж хараахан амжаагүй байна. Гэвч эдгээр тулгамдсан асуудлуудыг шийдэх эрэлт хэрэгцээ хурц тавигдах боллоо. Монгол улсын Их хурал, Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайд Х.Тэмүүжин "Бидэнд гэмт хэрэгтэй тэмцэж чаддаг хууль сахиулагч хэрэгтэй. Чадвар боловсролын хувьд хууль сахиулах түвшинд бэлтгэгдсэн, дээр нь үйлдэгдсэн гэмт хэргийг задлан шинжлэх аргачлалууд хэрэгтэй... хууль сахиулагч нь зөвхөн хуулийн мэдлэгээс гадна мэдээллийн технологийн мэдлэгтэй, санхүү эдийн засгийн мэдлэг, мэргэжилтэй байж сая энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж чадна. Хууль сахиулагч гэдэг гарцаагүй гэмт хэрэгтэй тэмцэх чадвартай, олон талын мэдлэгтэй,

мэргэшсэн, харилцааны соёлтой мэргэжилтэн байна. Үүнд хил хамгаалах мэргэжилтнүүд орно. Бид хилийн зөрчлийг буу зэвсгээр биш хуулиар таслан зогсоох цаг нь ирсэн" (3.12) гэсэн өндөр шаардлага, итгэл найдвар хилчдэд хүлээлгэв.

Энэхүү шаардлага зорилтуудыг хангахын тулд юуны урьд Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгож хилийг зөрчилгүй байлгах, гарсан тохиолдолд зэвсэг хэрэглэхгүйгээр шийдвэрлэх нөхцөл бүрдүүлэхэд онцлон анхаарч шийдвэртэй арга хэмжээ авахыг цаг үе шаардаж байна.

Энэ зорилгот нийцүүлэн ХСИС-ын шинжлэх ухаан технологийн газрын хил судлалын төвийн болон хилийн албаны сургуулийн эрдэмтэд, тухайлбал, гавьяат холбоочин, доктор (Ph.D), профессор, хурандаа Ц.Цэрэндоржийн удирдлага дор хэд хэдэн төсөл боловсруулан, хууль зүйн яам, хил хамгаалах байгууллагад гардуулаад байна. "Зэвсэгт хүчин ба хил хамгаалах байгууллагын уялдаа, холбоо бүтэц", "Төрөөс 2050 он хүртэл хугацаанд хилийн талаар баримтлах гурван шаттай хэрэгжүүлэх бодлогын үндэс", "Улсын хил, хязгаарын аюулгүй байдал, тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга зам", "Хилийн боомтын бүтэц, удирдлага, хамрах хүрээ, чиг үүргийн хэтийн төлөв", "Хил хамгаалах байгууллагад мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгох нь", "ХХЕГ-т цахим оффис нэвтрүүлэх нь", "ХХЕГ-ын харьяа хилийн зарим отряд, анги, заставт алба хааж байгаа ХЦАХ нарын дунд хийсэн хөндлөнгийн судалгаа" зэрэг захиалгат төслүүдийг боловсруулан, үр дүнг зохих байгууллагуудад хүлээлгэн өгөв.

Эдүгээ "ХСИС-ийн Хилийн албаны сургуулийн сургалтын чанарыг дэшлүүлэх арга зам", "Хил хамгаалах байгууллагын сургалтын тогтолцоог бүрүүлэх нь" зэрэг төслүүд дээр ажиллаж байна. Эрдэм шинжилгээ судалгааны ажилд төвийн эрдэмтэн доктор А.Муратхан, Д.Нямдорж, Х.Гөлгөө бид нараас гадна магистр хурандаа А.Батдорж, Х.Асхар зэрэг чадварлаг судлаачид идэвхтэй оролцов. Хууль сахиулахын их сургуулийн хүрээнд хилийн албаны эрдэм шинжилгээ сургалтад бий болсон нэг шинэчлэл нь тус сургууль дээр ахлагчийн бэлтгэлээс гадна, оюутан сонсогчдыг бакалавр, магистр, докторын хэмжээнд хүртэл цогцоор бэлтгэх шинэ тогтолцоог хэрэгжүүлж байгаа явдал юм. Эрдэм шинжилгээ сургалтыг хослох, онол ба практикийг тэгш эзэмшүүлж чадвар олгох, академик хэвшмэл хэлбэрээс прагматик, бүтээлч сэтгэлгээний сургалтын хэлбэрт шилжих, тэхдээ чанарыг гол үзүүлэлт болгох чиглэл баримталж байна.

Улсын хилийн тухай шинжлэх ухаан буюу хил судлалын шинжлэх ухаан зарим хүмүүст танин мэдэхүйн шинжтэй ойлголт байсан бол эдүгээ хилчдийн алба амьдралын жинхэнэ хэрэглүүр болох шатруу эргэлт буцалтгүй орлоо. Энэ шинжлэх ухаан

хилчдийн бодлого үйл ажиллагааны үндэс нь болж байх тавилантай юм. Монгол Улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлогод “хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг хил хамгаалалтын бодлого, үйл ажиллагааны үндэс болгох”-оор дэвшигдсэн зорилт аажим боловч үр дүнтэй хэрэгжсээр байна.

Сургалт-эрдэм шинжилгээнээс эрдэм шинжилгээ-сургалтын шинэ тогтолцоонд шилжиж орсны үндсэн шалтгааны нэг нь манай их сургуулийн бүтээгдэхүүн болох офицерууд зөвхөн сайн захирагч, бүтээлч дарга, өндөр мэргэжилтэн, шалгарсан менежер байх төдийгүй төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлогыг төгс болгох, түүнийг амьдралд бүтээлчээр хэрэгжүүлэгч өндөр зэрэглэлийн судлаачид, шинэ арга технологийг санаачлагчид байх ёстой гэж үзэж байна.

Энэ байр сууринаас авч үзвэл бидэнд шийдвэрлэх,

хийх ёстой тулгамдсан асуудлууд эрдэм шинжилгээ, сургалт аль алинд ч цөөнгүй байгаа нь эргэлзээгүй.

Ном зүй

1. Улсын хил хамгаалалтын түүхэн сургамж 80 жил. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. ХХЕГ. УБ., 2013 он
2. Ш.Доржбал. Хилээр овоглосон сургууль. УБ. 2004 он
3. Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага. Олон улсын эрдэм шинжилгээний хурал. Эмхэтгэл II. УБ., 2013 он
4. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. Монгол улсын олон улсын гэрээ. Төрийн мэдээлэл тусгай дугаар I боть. УИХ-ын Тамгын газар, ГХЯ. УБ., 2004 он
5. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. ХХЕГ. УБ, 2002 он

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦООНД ХИЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН АЖИЛЛАГААНЫ ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ: POTISION OF THE BORDER REPERESENTATIVES IN BORDER PROTECTION STRUCTURE AND ITS PROMOTION



Ц.Ганболд. ХСИС-ийн Хилийн сургуулийн захирал, цэргийн ухааны доктор, профессор, хурандаа
Ganbold.Ts. Director of Border Troops Institute, Law Enforcement Institute, Ph.D, Professor, Colonel

Abstract: Military politics than by any issue through diplomacy, agreement, consensus and wisdom to address current conditions prevalent in the border regime enforcement, border violations, incidents decision regulate Mongolian border delegate of great responsibility, and he has draft.

Улсын хил хамгаалалт нь хилийн дэглэмийн, хил орчмын дэглэмийн, цэргийн, инженер техникийн, улс төрийн, дипломатын, эдийн засгийн, тагнуулын арга хэмжээнээс бүрдэнэ. Монгол Улсын хилийн тухай хууль, хил хамгаалалтын дүрэмд “Хилийн асуудлаар байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тогтоосон дэглэмийг сахиулах, улсын хил дээр зөрчил, будлиан гарахаас сэргийлэх, хил дээр үүссэн хилийн аливаа асуудлыг

шуурхай шийдвэрлэх зорилгоор хилийн цэргийн байнгын бүрэлдэхүүнээс тусгайлан томилогдсон офицеруудын хүчээр хил залгаа улсын хил хамгаалах байгууллагатай хамтран явуулж буй дипломат арга хэмжээг хилийн төлөөлөгчийн ажиллагаа» гэх бөгөөд улс орны эрх ашгийг улсын хил дээр хамгаалах арга хэлбэрийн нэг юм” гэж заажээ.

Монгол Улсын хилийн төлөөлөгчийн